МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 02 өдөр Дугаар А/185 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын тусгай сан Шинжлэх ухаан технологийн сан, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас санаачлан "Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацыг нутагшуулъя" аяны үйл ажиллагааг Хөвсгөл аймагт зохион байгуулсантай холбогдуулан гарсан зардалд 8.154.400 (Найман сая нэг зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 8.154.400 (Найман сая нэг зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022